

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн жрхийг хамгаалах ОУ-ын өдрийг угтан зохион байгуулсан “Бид чадна” өдөрлөгийн тайлан

2018.11.06

Амардалай

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан 2018 оны 11 сарын 02-ны өдөр сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асран хамгаалагчдын дунд “Бид чадна” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, Халамжийн мэргэжилтэн Д.Цэцэгбалам Зорилтод бүлгийн сургалт, ЭМТ-ийн эмч М.Манал “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний” талаар мэдээлэл хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд буухиа тэмцээн, урлагийн бага наадмыг зохион байгууллаа. Мөн өдөрлөгийн үеэр Хөдөлмөр Халамж Үйлчилгээний газрын дарга Хишигдаваа оролцож ард иргэд өөрт хэрэгцээтэй мэдээллээ асууж ярилцалгын цагийг өрнүүллээ.



Буухиа тэмцээнд П.Болормаа ахлагчтай баг 1-р байр, Б.Юра ахлагчтай баг 2-р байр, Ц.Оюунбилэг ахлагчтай баг 3-р байранд шалгарлаа.



Морь уралдуулах тэмцээнд Ц.Энхцэцэг 1-р байр, сандалтай тойрон бүжгийн тэмцээнд О.Ганбат 1-р байр, 4 бэрх буулгах тэмцээнд О.Ганбат 1-р байранд тус тус шалгарлаа.



Урлагийн бага наадамд зохиолын дууны тэмцээнд 18-25 насны ангилалд Л.Уртнасан 1-р байр, 25-35 насны ангилалд Д.Дарьсүрэн, 35-45 насны ангилалд Н.Зулбадам 1-р байр, 45-аас дээш насныхны ангилалд П.Амгаланбаатар 1-р байр, Хөгжмийн төрөлд Б.Бат-Амгалан тус тус шалгарлаа.

